

**Увс аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хуралд бие даан нэр дэвшигч**

**С Батсуурийн мөрийн хөтөлбөр**

**1. Гэр бүлийн хөгжил, хувь хүний хөгжил**

- Иргэдийн хувиараа хөдөлмөр эрхлэх боломжийг дэмжиж шаардлагатай техник, тоног төхөөрөмжийг худалдан авах хөнгөлөлттэй зээлд хамрагдах боломжийг судлаж танилцуулах
  - Амжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрхийн гишүүдийг мэргэжил эзэмшүүлэх сургалтанд хамруулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.
  - Малын фермерийн аж ахуй эрхлэгчид болон шинээр эрхлэгчдийг төсөл хөтөлбөрт хамрагдах боломжийг судлаж танилцуулан дэмжиж ажиллана.
  - Мал маллагааны туршлагатай, мал аж ахуйн салбарт ажиллах боломжтой амжиргааны түвшин доогуур мал цөөтэй айл өрхийг төсөл хөтөлбөрт хамруулж малжуулна.
  - Жимс жимсгэний аж ахуй эрхлэгчдийг төсөл хөтөлбөрт хамрагдах боломжийг судлаж танилцуулан дэмжиж ажиллана.
  - Аймгийн Хөдөлмөр Халамжийн үйлчилгээний газартай хамтран багийн иргэдийг түр ажлын байраар хангах тал дээр хамтран ажиллана.
  - УБ хотод багийн иргэдийн ногооны үрний борлуулалт хийх сувагтай болгох талаар хувь хүмүүс болон аж ахуйн нэгжүүдэд санал тавьж бодит үр дүнд хүргэн ажиллана.
  - Аймгийн Цагдаагийн газартай хамтран малын хулгайн гэмт хэргийг бууруулах тал дээр анхаарч ажиллана.
- 2. Байгаль орчны хөгжил**
- Ногоон байгууламжуудыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 1,2 дугаар буудлуудын засмал замын дагуу мод тарих ажлыг багийн иргэдийн оролцоотойгоор хийж гүйцэтгэнэ.
  - Багийн доод талд хурийтлагдсан хур хогийг цэвэрлэх ажлыг сумын Хот тохижилт үйлчилгээний газартай хамтран төсөл хөтөлбөрт хамруулж цэвэрлэх ажлыг зохион байгуулна.

- Улаантолгойн усан сангийн усны нөөцийг нэмэгдүүлэх, инженерийн байгууламжийг засаж цэвэрлэх ажлуудыг төсөл хөтөлбөрийн хүрээнд хийж гүйцэтгүүлэх.
3. Дэд бүтэц
- Аймгийн гэр хорооллод хийгдэж буй дулаан халаалтын ажлыг өөрийн багийн нутаг дэвсгэрт хийх бүхий л боломжийг судлаж холбогдох газарт нь санал хүсэлт тавьж ажиллана.
  - Гэр хороолын доторх зам, гэрэлтүүлэг зэрэг ажлуудыг орон нутгийн төсөл хөтөлбөрт хамруулах талаар холбогдох газарт нь санал хүсэлт тавьж ажиллана.
  - Тоосгоны заводаас “Тус” дэлгүүр хүртэлх зам дагуу гэрэлтүүлэгийг сумын төсөв хөтөлбөрт тусгуулан хэрэгжүүлнэ.